

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
6 дугаар хавсралт

БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ЗАХИРГАА,  
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАЙЦААГЧ Н.МӨНХЦОЛМОН  
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт                                                    | Гүйцэтгэлийн түвшин                                                                                                         |                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                  |                          |                 |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------|---------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-----------------|
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                  |                                                                     | Суурь түвшин                                                                                                                | Хүрэх түвшин                                                                                                                                | Хүрсэн түвшин (биелэлт)                                                                                                                                                                                                                                                                                                          | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                  |                                                                     | 1                                                                                                                           | 2                                                                                                                                           | 3                                                                                                                                                                                                                                                                                                                                | 4                        | 5               |
| Зорилт 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |                                  |                                                                     |                                                                                                                             |                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                  |                          |                 |
| Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах |                                  |                                                                     |                                                                                                                             |                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                  |                          |                 |
| 1.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | Арга хэмжээ 1.1.1                | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд эрх зүйн шинэчлэлтийг хэрэгжүүлсэн онцлог жил тохиож байна. Хуулийн шинэчилсэн найруулга, түүнтэй холбогдон гарсан эрх зүйн баримт бичиг, чиглэл, зөвлөмж заавар, аргачлалыг нэг мөр хэрэгжүүлэхээр холбогдох албан хаагчдад тухай бүр мэдээлэл хүргэж, хэрэгжилтийг зохион байгууллаа. Энэ | Улирал бүр               | 97,7            |

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                   |                                                                                                      |                                                              |                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |         |   |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|---|
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                   |                                                                                                      | ажлыг зохион байгуулсан.                                     |                                                                                                                                                                                      | <p>чиглэлээр дотооддоо нийтдээ 17 удаагийн мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохион байгуулсан байна.</p> <p>2024 оны эхний хагас жилийн байдлаар дээд газраас ирүүлсэн 60 эрх зүйн актыг 97,7%-тай хэрэгжүүлэв.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                 |         |   |
| <b>Зорилт 2. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт</b>                                                                                                                                                                                                                                                                                      |                   |                                                                                                      |                                                              |                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |         |   |
| Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах |                   |                                                                                                      |                                                              |                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |         |   |
| 1.                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | Арга хэмжээ 2.1.7 | Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн өглөг авлагаас бусад өглөг, авлагыг хугацаанд нь барагдуулна. | Бусад өглөг авлага санхүүгийн тайлангаар баталгаажсан байна. | <p>а)Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг оны эхний дүнгээс 50 хувиас доошгүй барагдуулах.</p> <p>б)Нийгмийн даатгалын байгууллагын бусад өр, авлагыг бүрэн барагдуулах.</p> | <p>а)Нийгмийн даатгалын сангийн бусад авлага 2023 оны жилийн эцсээр 525,1 сая төгрөг байснаас 2024 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 522,5 сая төгрөг болж 2,6 сая төгрөг төлөгдсөн.</p> <p>Уг авлага нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгон авч байсан 118 иргэнтэй холбоотой үүссэн авлага бөгөөд эдгээр иргэдийн холбогдох материалыг Цагдаагийн хэлтэст хэрэг бүртгэлийн хэрэг нээж, 2024 оны 08 дугаар сард Багануур дүүргийн Прокурорын газарт шилжүүлсэн. Уг асуудлыг шалгаж, эцэслэсэн шийдвэр</p> | Сар бүр | 5 |

|  |  |  |  |                                                 |  |  |
|--|--|--|--|-------------------------------------------------|--|--|
|  |  |  |  | гараагүй тул төлөлт хийгдээгүй хүлээгдэж байна. |  |  |
|--|--|--|--|-------------------------------------------------|--|--|

### Зорилт 3. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх

|    |                   |                                                                                                                                                                                                                                                         |                                                           |                                                                                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |         |    |
|----|-------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|----|
| 1. | Арга хэмжээ 3.2.1 | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг нийт аж ахуйн нэгж байгууллагын 20 хүртэл хувьд мөн нийгмийн даатгалын 2-3 сангийн зарцуулалтад дотоодын хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70.0 аас доошгүй хувийг барагдуулж ажиллана. | Илэрсэн төлбөр зөрчлийн 72,6 хувийг барагдуулж ажилласан. | Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулах | Гадаад болон дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг газрын даргаар батлуулан ажиллаж байна.<br><br>2024 оны тайлант хугацаанд сайн дурын даатгуулагч 386 иргэнд хугацаандаа төлөөгүй шимтгэлд ногдох 11353.9 мянган төгрөгийн алданги ногдуулж, бүрэн барагдуулаад байна.<br><br>2024 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн байдлаар дотоодын хяналт шалгалтаар 9 ажил олгогч, байгууллагын 12 даатгуулагчид холбогдох 597,1 мянган төгрөгийн акт тогтоогдож бүрэн барагдуулсан байна.<br><br>1 тэтгэвэр авагчид дутуу олгосон 5143,0 мянган төгрөгийг олгож, 1 тэтгэвэр авагчид илүү | Сар бүр | 50 |
|----|-------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|----|

олгосон 1413,2 мянган төгрөгийг бүрэн төлүүлсэн.

Ажилгүйдлийн тэтгэмж авсан 284 иргэний тэтгэмжийн хувийн хэрэг материалыг тэтгэмжийн программ болон шинэ системд нэгдсэн лавлагаатай тулган шалгалаа. Мөн жирэмсэн амаржсаны болон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж нийт 2484 эмнэлгийн хуудасны бодолтыг шалган шийдвэрлэсэн байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийх аудитын удирдамж”-ийн дагуу 2023 оны шилэн дансны мэдээллийг шалгах ажлыг 2024.01.02-04-ний хооронд хийж гүйцэтгэлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 01/1107 дугаар “Дотоод хяналт шалгалтыг эрчимжүүлэх тухай” албан бичгийн дагуу цахимаар болон жагсаалтаар олгосон тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг шалгалаа. 5463 тэтгэвэр авагчийн тэтгэвэр олголтоос

|  |  |  |  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |  |
|--|--|--|--|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|
|  |  |  |  | <p>шалгалтаар 100,0 мянган төгрөгийг 32 тэтгэвэр авагчид илүү олгосон, 4 тэтгэвэр авагчид дутуу олгосон нийт 3600,0 мянган төгрөг зөрчил илэрлээ. 3600,0 мянган төгрөгөөс 4 хүний 400,0 олгосон, 32 хүний 3200,0 мянган төгрөгийг төлүүлэхээс 3150,0 мянган төгрөгийг тэтгэврийн даатгалын санд төлж барагдуулсан. Тэтгэмжийн даатгалын сангаас 1213 даатгуулагч үйлчилгээ авснаас 5 хүний 6 удаагийн 7620,1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 2 удаагийн 75,5 мянган төгрөгийн зөрчлийг зассан, ажилгүйдлийн тэтгэмж авсан 4 даатгуулагчийн 2 хүнд давхардуулан илүү олгосон, ажилд орсон 2 хүнд хоногийн тооцоо буруу хийж илүү олгосон 7544,5 мянган төгрөгийн акт тогтоож 614,6 мянган төгрөгийг санд төлүүлж 6929.8 мянган төгрөгийг барагдуулаагүй байна. 2024 оны 01-06 дугаар сард олгосон тэтгэврийн олголтыг шалгаж холбогдох байцаагч, болон тэтгэвэр олгосон банкуудад зөвлөмж өгч ажиллалаа.</p> |  |
|--|--|--|--|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|

|   |                   |                                                                                                                                                                                                                                                              |                                                                                                                        |                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |           |     |
|---|-------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|-----|
| 2 | Арга хэмжээ 3.2.2 | Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг хагас, бүтэн жилээр гаргаж 2024 оны 6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ний өдрөөр тасалбар болгон ХШГ-т тайлагнах, Илэрсэн зөрчил, дутагдлын 70 аас доошгүй хувийг барагдуулсан байх | Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийг 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр шинэчлэн байгуулсан. | Холбогдох судалгаа, тооцоо, дүгнэлтэд үндэслэн Хилийн цэргийн анги, тусгай салбартай хамтарсан шалгалт хийж үр дүнг тооцож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж ажиллах | Хил хамгаалах ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хооронд хамтран ажиллах санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хүрээнд Хилийн цэргийн 0252 дугаар ангийн албан хаагч, үйлчилгээний ажилтны ээлжийн амралтын цалинг нийт дүнгээр тайлагнасан, эмэгтэй цэргийн албан хаагч болон үйлчилгээний албан хаагчдын жирэмсний болон амаржсан хугацаа, хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааны шимтгэл төлөлтийг тус ангиас гаргаж ирүүлсэн жагсаалтын дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, тайлагналын зохих хэсгүүдийг холбогдох баримтыг үндэслэн шалгаж цэргийн албан хаагч нэг эмэгтэй, энгийн албан хаагч 4 даатгуулагчийн жирэмсэн амаржсаны амралттай байсан хугацаа, хүүхэд асрах чөлөөтэй хугацааны эрүүл мэндийн даатгалын болон нийгмийн даатгалын шимтгэл нийт 349,2 мянган төгрөгийг, түүнд ногдох 174,5 төгрөгийн алдангийн хамт нөхөн төлүүлэхээр тогтоосон улсын байцаагчийн нийт 523,7 мянган төгрөгийг төсөв | Тухай бүр | 100 |
|---|-------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|-----|

|  |  |  |  |  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |  |  |
|--|--|--|--|--|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|
|  |  |  |  |  | <p>шийдэгдээгүйгээс 2023 оны 12 жилийн эцсийн байдлаар барагдаагүй, 2024 оны эхний хагас жилд 523,7 мянган төгрөгийг бүрэн барагдуулсан байна. Тус ангиас нийт 35 ажилтны жагсаалтыг холбогдох баримтын хамт ирүүлсэн бөгөөд түүнд цэргийн албан хаагч болон энгийн алба хаагч эхийн хүүхэд асрах чөлөөтэй, жирэмсний болон амаржсаны амралттай хугацааг орхигдуулсан гэх 9 албан хаагчаас холбогдох тушаалгүй, материалын бүрдэл хангахгүй, хуулийн зохицуулалтад хамаарахгүй нийт 4 хүний асуудлыг шийдвэрлэх боломжгүй, ээлжийн амралтын мөнгийг салгаж засварлуулах нийт 23 хүний материалаас бүрдэл хангахгүй болон материал дутуу, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, нас барсан зэргээр хасагдаж 9 албан хаагчийн ээлжийн амралтыг бөөн тайлагнасныг засварлахаар шийдвэрлэж, бусад 3 алба хаагчийн тушаал холбогдох баримт байхгүй тул шийдвэрлэх боломжгүй байсан болно.</p> |  |  |
|--|--|--|--|--|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|

|   |  |                                                                                                                         |   |                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |  |  |
|---|--|-------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|
|   |  |                                                                                                                         |   |                                                                                                                     | Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 08/2075 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжийн дагуу 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийг дуусталх хугацаанд Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын Багануур салбарын 2019-2024 оны санхүүгийн болон холбогдох бусад баримтад үндэслэн нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн туслалцааг хуулийн хүрээнд үзүүлж, зааварчилгаа өгөв. |  |  |
| 3 |  | ҮОМШӨ-ний сангийн зарцуулалтад шалгалт хийж илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага тооцож, үр дүнг эхний хагас жилээр | - | ҮОМШӨ-ний сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл болон анхан шатны баримтад тулгуурлан | Салбарын Улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 13-07/08 дугаартай “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу тус газарт Нийгмийн даатгалын ерөнхий                                                                                                                                                                                                                                                                                                    |  |  |

|  |                   |                                                                               |  |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |                    |    |
|--|-------------------|-------------------------------------------------------------------------------|--|----------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|----|
|  | Арга хэмжээ 3.2.3 | тайлагнаж<br>илэрсэн<br>зөрчлийн 80<br>хүртэл хувийг<br>барагдуулж<br>ажиллах |  | шалгаж<br>шийдвэрлэх | <p>газрын Хяналт шалгалтын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч Б.Хишигжаргал, Г.Бямбажаргал, О.Пүрэвжав, ахлахаар Нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Г.Ганбаяр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2024 оны 04 дүгээр сарын 08-наас 12-ны өдрүүдэд ирж ажиллав.</p> <p>Шалгалтаар Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалттай холбогдох санхүүгийн баримт материал, тус сангийн цахимжилт, тус сангаас санхүүжилт авсан аж ахуйн нэгж байгууллага, иргэд мөн өмнөх онуудад тус санд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн, акт, албан шаардлагын биелэлт, үр дүнг шалгасан.</p> <p>Тус сангаас 2021-2023 онд тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авч буй нийт тэтгэвэр авагчдын тэтгэвэр тогтоолтын</p> | Хоёр дугаар улирал | 90 |
|--|-------------------|-------------------------------------------------------------------------------|--|----------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|----|

|  |  |  |  |  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |  |
|--|--|--|--|--|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|
|  |  |  |  |  | <p>үндэслэлийг хувийн хэрэгт бүрдүүлсэн баримт материалд тулгуурлан шалгах, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж болон хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөрийн бодолт олголтыг үндсэн баримттай тулган шалгах, 2021-2023 онд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэл төлөлт зэргийг шалгав. Нүүрэлтэй эсгий ХХК-д Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 32/34 дугаартай Улсын ахлах байцаагчийн 2081,8 мянган төгрөгийн акт тогтоогдож, 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар барагдуулаагүй байна. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч 3 иргэнд дутуу олгосон 5118,3 мянган төгрөгийг тэтгэвэр авагчид нөхөн олгох, 1 хүнд илүү олгосон 245,1 мянган төгрөгийг буцаан төлүүлэх тухай Нийгмийн даатгалын ерөнхий газрын Улсын ахлах байцаагчийн 2024 оны 07</p> |  |
|--|--|--|--|--|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|

|   |                   |                                                                                                                                                                                                                  |   |                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |           |     |
|---|-------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|-----|
|   |                   |                                                                                                                                                                                                                  |   |                                                                                                                              | дугаар сарын 08-ны өдрийн 32/35 дугаартай акт тогтоогдож бүрэн барагдуулсан байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                    |           |     |
| 4 | Арга хэмжээ 3.2.4 | Хяналт шалгалт хийсэн объектын тоогоор гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | - | Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, ирэлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах | Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч Б.Хишигжаргал, О.Пүрэвжав, Багануур дүүргийн Хөдөлмөр, халамжийн хэлтсийн Хөдөлмөрийн улсын байцаагч н.Номин нарын бүрэлдэхүүнтэй тус дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийлээ. Тус газарт Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч байхгүй болно. | Тухай бүр | 100 |
| 5 |                   | Дотоодын хяналт шалгалт болон НДЕГ, хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн төлбөр                                                                                                                                 |   | Шалгалтын үр дүнг хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох                                                     | Дээд газрын шалгалтаар тогтоогдсон оны эхний ажилгүйдлийн тэтгэмжийн актын үлдэгдэл нэг хүний 568,4 мянган төгрөгөөс 100,0 мянган төгрөгийг барагдуулсан. Оны эхний үлдэгдэлтэй 12 тэтгэвэр авагчийн 102270,1 мянган                                                                                                                                                                                                  |           |     |

|  |                   |                                                                                                                                                                                         |  |                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |           |    |
|--|-------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|-------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|----|
|  | Арга хэмжээ 3.2.5 | зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2024 оны 06 дугаар сарын 20, 11 дугаар сарын 20-ны өдрийн дотор ХШГ-т хүргүүлнэ. |  | шийдвэр гаргуулах | төгрөгийн актын төлбөрөөс 2923,9 мянган төгрөгийг барагдуулж 99346,2 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Өнгөрсөн оны хуурамч бичиг баримтаар тэтгэвэр тогтоолгосон 20 тэтгэвэр авагчид 432,593.95 мянган төгрөгийг тэтгэврийн даатгалын санд буцаан төлүүлэхээр тогтоосон улсын байцаагчийн актын оны эхний үлдэгдэл 409822,9 мянган төгрөг байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 01/1107 дугаар “Дотоод хяналт шалгалтыг эрчимжүүлэх тухай” албан бичгийн дагуу цахимаар болон жагсаалтаар олгосон тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг шалгалаа. Шинэ системээр 2024 оны 2 дугаар сарын тэтгэвэр олголтоос эхлэн файл бэлтгэн банкуудад хугацаанд нь хүргүүлэн ажиллажээ. 2024 оны 6 дугаар сарын бэлтгэсэн файлаар 32 тэтгэвэр авагчид тус бүр 100, мянган төгрөгийн нэмэгдэл илүү явсан байгааг илрүүлэн тайлант хугацаанд улсын байцаагчийн акт тогтоож 32 хүнээс уг илүү олгосон 3150,0 мянган төгрөгийг барагдуулсан байна. Ажилгүйдлийн | Тухай бүр | 80 |
|--|-------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|-------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|----|

|  |  |  |  |  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |  |  |
|--|--|--|--|--|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|
|  |  |  |  |  | <p>тэтгэмжийн акт тогтоосон 4 хүний 7544,5 мянган төгрөгөөс 614,6 мянган төгрөгийг санд төлүүлж 6929.8 мянган төгрөгийг төлж барагдуулаагүй байна.</p> <p>Өмнөх оны актын үлдэгдэл 512661.4 мянган төгрөгөөс 3023.9 мянган төгрөгийг барагдуулж 509637.5 мянган төгрөгийн барагдуулаагүй байна.</p> <p>Энэ онд тогтоосон актын нийт дүн 16714.5 мянган төгрөгөөс 4361.6 мянган төгрөгийг барагдуулж 12352.9 мянган төгрөгийн барагдуулаагүй актын үлдэгдэлтэй байна.</p> |  |  |
|--|--|--|--|--|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|

#### Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт

Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах

|    |                                                                                             |                                                                                                   |                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                    |  |  |
|----|---------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|
| 1. | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 100%-тай хэрэгжсэн байна. | Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал | Нийгмийн даатгалын байгууллагаас үйлчилгээ авах хүсэлт ирүүлсэн иргэд, даатгуулагчдын хүсэлтийг өргөдөл, гомдлын дэвтэрт бүртгэж, шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар |  |  |
|----|---------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|

|  |                   |                                             |                                           |                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |           |     |
|--|-------------------|---------------------------------------------|-------------------------------------------|-------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|-----|
|  | Арга хэмжээ 4.1.2 | хугацаанд тайлагнасан байна.                |                                           | бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | <p>нийт 2097 хүсэлт бүртгэгдсэнээс 2071 хүсэлт буюу 98,8%-ийг шийдвэрлэж, үлдсэн 26 хүсэлтийг хуулийн хугацаанд судалж байна.</p> <p>Нийгмийн даатгалын цогц системийг хөгжүүлж, нэвтрүүлэх ажлаас шалтгаалан зарим даатгуулагчдын тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь тогтоох, олгох ажлууд удааширснаас үүдэн Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд бүртгэгдсэн тус газрын үйлчилгээтэй холбоотой 8 гомдол, 1 санал, 1800-1200 дугаарт бүртгэгдсэн 2 гомдол, иргэн биечлэн ирж гаргасан 1 гомдол, нийт 12 гомдол, саналыг 24 цагт багтаан 100% шийдвэрлэж, даатгуулагчдад тухай бүр мэдээлэл хүргэж ажиллалаа.</p> <p>2024 оны 1, 2, 3 дугаар улирлын өргөдөл, гомдлын тайланг НДЕГ-т товлосон хугацаанд хүргүүлсэн.</p> | Тухай бүр | 988 |
|  |                   | Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс                 | Тайлант хугацаанд албан тушаалд шилжин томилогдсон албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |           |     |

123

|    |                   |                   |                                                                                                                                |                                                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |           |     |
|----|-------------------|-------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|-----|
| 2. | Арга хэмжээ 4.1.7 | байгуулсан байна. | албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах. | урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | мэдүүлгийг хянуулах хүсэлтийг АТГ-т хүргүүлсэн. АТГ-аас ирүүлсэн хариуг үнлэслэн ХАСХОМ мэдүүлсэн.<br><br>Тайлант хугацаанд төрийн албаны тухай хууль тогтоомж түүнтэй холбогдон гарсан дүрэм журам, төрийн албаны болон үйлчилгээний стандартыг мөрдөж, төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчил гаргалгүй ажиллалаа. | Тухай бүр | 100 |
|----|-------------------|-------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|-----|

Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах

|    |  |                                                                                                          |                                                                                                                                   |                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |  |  |
|----|--|----------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|
| 3. |  | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 2 удаагийн сургалтад 47 иргэд, даатгуулагчийг хамруулсан. | Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилж, хамралт нэмэгдсэн байна. | Сургагч багш нар ажил олгогч байгууллагуудын дарга, захирал, нягтлан бодогч нарт зориулсан Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хууль тогтоомж, нийгмийн даатгалын шинэчилсэн цогц программ, цахим үйлчилгээний талаарх зөвлөгөө мэдээллийг хүргэх 13 удаагийн танхимын сургалт 5 удаагийн явуулын үйлчилгээ, сургалт зохион байгуулж, нийт 311 байгууллага, 1264 даатгуулагч, иргэдэд хүргэсэн байна. |  |  |
|----|--|----------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|

|  |                   |  |  |  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |           |     |
